

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА  Д.БАТСҮХ

2023 оны 03 дугаар сарын 24

УДИРДАМЖ

2023 оны 03 дугаар сарын 24

Улаанбаатар хот

**“ТА-БИ-ТА, БИЕ БИЕДЭЭ МЕНТОР БАЙЯ”
нөлөөллийн ажил зохион байгуулах тухай**

Зорилго:

Газрын даргын 2018 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/34 тушаалаар батлагдсан. “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 5.1.4, 5.2.1, 5.2.5 дахь заалтыг хэрэгжүүлэх, албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, дасгал хөдөлгөөн хийж хэвших, харилцаа хандлага, шинийг санаачлагч байхад бусдыгаа уриалах, төрийн албан хаагчийн соёлд харилцан суралцахад оршино.

№	Үйл ажиллагааны чиглэл	Хугацаа	Тайлбар
1	2	3	4
1.	Өглөөний дасгал ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлэх	4, 5 дугаар саруудад	Өдөрт тогтсон цаг нэгдсэн талбайд цугларч дасгал хөдөлгөөнийг хийж хэвших. 14 ⁰⁰ цагт тогтмол хийнэ. Мөн хөгжөөнд асуулт хариултыг зохион байгуулна.
2.	Урлагийн сэтгэл засал нөлөөллийн арга хэмжээ	4 сард	Уянгалаг хөгжмийн аянд зураг зурж гэрээ, ажлын өрөөгөө гоёх бүтээлээ өөрийн гараар зурж үзэх үү. Та зурж чаддаггүй гэж битгий санаа зовоорой танд зааж зөвлөх учир тэр бодлоо мартаад зүгээр өөртөө итгэлтэй байх, хамт олноороо “Art” арга хэмжээ зохион байгуулах
3.	Спорт заал авах /Сагс бөмбөг, гар бөмбөг/	4, 5 дугаар саруудад	Спорт заланд 14 хоногтоо 1 удаа тоглож хэвших
4.	Эрүүл хооллолт	4, 5 дугаар саруудад	Зохистой хооллолтыг хэлбэрүүдийг сонгох, эрүүл хооллолтын сургалтад хамрагдах, өөрийн биеийн үзүүлэлт тохирсон ус ууж хэвших, бие биедээ эрүүл мэндийн талаарх мэдлэгээ хуваалцах
5.	Төрийн албан хаагчийн соёл	4, 5 дугаар саруудад	Төрийн албан хаагчийн соёлд суралцах, өөрийн туршлага хуваалцах, бусдад менторлох үүнд: - Цаг хэрхэн баримтлах, ажлын цагийг үр бүтээлтэй өнгөрөөх

			- Ажлын байрын эмх цэгц, бичиг хэргийн соёл - Албан хаагч хоорондын үр дүнтэй харилцаа - Ажил хэрэгч хувцаслалт - Шинийг санаачилсан байдал зэрэг орно.
6	Сайн дурын ажил хийх	4, 5 дугаар саруудад	Албан хаагчид сардаа 1 удаа сайн дурын ажлыг байгууллагадаа болон бусад нийгэмд санаачлан зохион байгуулах
7	Явган алхалт шинэ маршрут гаргаж аялах	4 сард	Хамт олноороо амралтын өдөр ууланд алхах, нэг өдрийг хөгжилтэй өнгөрөөх, мөн шинэ маршрутыг туршин үзэх, алхалтаар явахдаа хүн бүр өөрсдийн хувийн бэлтгэлийг сайтар хангаж өдрийн хоол хүнсээ гэрээсээ бэлтгэн ирэх
8	Гэр бүлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх	5 сард	Дэлхийн гэр бүлийн өдрийг байгууллагын албан хаагчдын гэр бүлд чиглэн зохион байгуулах, үүнд гэр бүлийн гишүүдийн ажлын байртай танилцах хотын аялал зохион байгуулах
9	Сэтгэл хөдлөлийн карт ашиглах нь	4, 5 дугаар саруудад	Тухайн өдөр таны сэтгэл зүйн байдал ямар байгааг өнгийн картаар илэрхийлж наах, 1. Ярилцах хэрэгцээ байна. 2. Ганцаараа байхыг хүсэж байна. 3. Би ууртай байна. 4. Чимээгүй байгаарай. 5. Би аз жаргалтай байна. 6. Хамт хоол иднэ шүү. гэх мэт өнгийн картаа бусдадаа төвөг удалгүй ойлголцох, илэрхийлэх

Хугацаа:

2023 оны 04 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл

Шагнал, урамшуулал:

Нөлөөллийн ажилд хамгийн идэвхтэй оролцсон гурван албан хаагчийг гадаад улсад явуулна.

Хүрэх үр дүн:

Дээрх үйл ажиллагаанд идэвхтэй оролцож хоёр сарын хугацаанд хамт олноороо зөв дадал хэвшлийг бий болгож, ажлын ачаалал, стерссийг даван туулах зэрэг нөлөөллийг бий болно. Мөн албан хаагчдад эрүүл мэндийн боловсрол олгож, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг хийж хэвшүүлсэн байна. Шинэ залуу албан хаагчдад үлгэр дуурайлал үзүүлэн менторлон ажиллаж, хувийн зохион байгуулалт сайжирна.

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА



Д.ГАНБОЛД

БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



Б.ЭНХЦЭЦЭГ